

## “*REX MONGOLICA*” БУЮУ ИХ МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН “ЭНХЭЭР ТОХИНУУЛАХ” ҮЗЭЛ САНААНЫ ТУХАЙ

Г.Баасанхүү\*

**Д**элхийн түүхэнд аль нэг улс, үндэстэн хүчирхэгжихдээ өөрийн засаглалыг бэхжүүлэхийн хамт газар нутгаа өргөжөөлж амьдралын орон зайгаа тэлэх, өөрийн соёл иргэншлийг бусдад тулган тархаах бодлогыг явуулсаар ирсэн. Олон улсын харилцааны онолд эртний улсуудаас 1648 оны Вестфалийн гэрээ хүртэлх түүхийг эзэнт гүрнүүдийн цикл буюу хэмнэл байдлаар судлахыг санал болгосон хандлага байдаг.<sup>1</sup> Ингэж үзвэл тусгаар улс хоорондын эрх зүйт харилцаа үүсэхээс өмнө буюу Европ төвтэй олон улсын харилцааны түүхээс өмнөх улс хоорондын харилцаа, олон улсын харилцааны түүхэн тойм нь илүү хүчирхэг улс гүрэн байлдан дагуулах бодлогоор дэлхийг нэгэн дээвэр доор нэгтгэхийг эрмэлзсэн эзэнт гүрнүүдийн түүх гэж болно. Энэ утгаар XIII-XIV зууны Их Монгол улс нь дэлхийн сонгодог эзэнт гүрний тод жишээ мөн билээ.

Египетчүүд, Ромчууд, Арабуудын дараа дэлхийн бодлогыг бараг хоёр зууны туршид тодорхойлолцож чадсан монголчуудын байлдан дагууллын нууц, төрийн бодлого, зэвсгийн эрдэм, нүүдлийн соёл бүрэн тайлагдаагүйн нэг адил тэдний гадаад бодлогын хосгүй ур чадвар нь тухайн цаг үеийнхээ хувьд шинэлэг бөгөөд дэвшилтэт үзэл санаагаар дүүрэн байсныг цохон тэмдэглэх хэрэгтэй юм. Түүхэн тодорхой үед хүчирхэгжсэн эзэнт гүрэн, эсвэл их гүрэн олон улсын харилцааны өөрийн бие даасан системийг үүсгэж чаддаг байсан. Сул дорой нь устаж үгүй болох, хүчирхэг нь бусдыгаа байлдан дагуулах зүй тогтлоор тэр цагт улс хоорондын харилцааны түүх хөгжиж байжээ. Ийм ч учир дэлхийн хэмжээнд бодлого явуулах чадвартай улс төрийн зохион байгуулал нь орчин цагийнх шиг үндэсний улс биш, харин эзэнт гүрэн байлаа.

Олон улсын харилцааны онолд XVII зуунд анх Европын улс гүрнүүд олон улсын харилцааны сонгодог системийг үүсгэсэн гэж үздэг. Ингэж үзвэл Вестфалиас эхтэй Европ төвтэй олон улсын харилцааны системээс өмнөх олон улсын харилцаа өөрийн зүй тогтол

\* МУИС, ОУХС-ийн багш, докторант

<sup>1</sup> К.С.Гаджиев, “Геополитика”, М.1997., стр. 19



хуульгүй мэт, харанхуй бүдүүлэг үе байсан мэтээр олонх нь төсөөлдөг байгаа юм. Их Монгол улсын түүхтэй холбогдох эх сурвалжуудтай сайтар танилцвал тухайн үеийн дундад зууны нийгэм, олон улсын харилцаанд талын монголчууд даяаршлын эхний алхмуудыг хийж, өрнө дорны соёл иргэншлийн ололтуудыг харилцан түгээх гүүр болж, олон улс үндэстэн, олон шашин соёлыг нэг дээвэр доор нэгтгэж чадсан төдийгүй, олон улсын худалдааны гол замуудыг хянан хамгаалж чөлөөт худалдаа хөгжих нөхцлийг хангаж байснаараа олон улсын эдийн засгийн харилцааны хөгжилд өөрийн үнэт хувь нэмрийг оруулж, олон улсын харилцааны хөгжилд дэвшилтэт алхмууд хийж байсан нь олон талаар нотлогддог.

Монголын байлдан дагуулал түрэмгий шинжтэй байсан нь үнэн боловч энэ нь хөрш болон бусад бүс нутгийн их гүрний үл ойшоосон байр сууринаас хандсан "дуудлага"-д өгсөн "хариулт" байсан гэж дүгнэж болно. Нүүдэлчин монголчууд Азиас Африк, Өмнөд Хятадын тэнгисээс Өрнөд Европ хүртэл өргөн уудам газар нутгийг хамран цогцлоож чадсан өөрийн эзэнт гүрнийг тохинуулахдаа хүчинд дулдуйдахаас илүүтэй ухаан, арга самбаад тулгуурлаж байсныг, тэдний гадаад бодлого нь түрэмгийлсэн дайнч байхаас илүүтэй "энхээр тохинуулах" үзэл санаанд тулгуурлаж байсныг олон судлаачид үнэлэн дүгнэсэн байдаг. Тухайлбал, В.Котвич, Ф.Фернандос-Арместо<sup>2</sup>, А.Тойнби<sup>3</sup> нар Монголын байлдан дагууллыг дэлхийн түүхэнд эерэг талаас нь нөлөөлсөн гэж үздэг бөгөөд өөрөөр хэлбэл, тухайн үеийн олон үндэстний хөгжил, цаашдын төлөвшилд эергээр нөлөөлсөн, олон улсын харилцаанд болон дэлхийн түүхэнд хөгжлийг түргэтгэх олон хувь нэмрийг оруулсан, монголчуудын гадаад бодлогод түрэмгийллээс илүүтэй "энхээр төвшитгөх" үзэл санаа зонхилж байсныг цохон тэмдэглэсэн байдаг. Үнэхээр XIII-XIV зууны үед хүчтэй илэрч байсан "монгол энх төрийн" үзэл санаа нь бидний санахад хүн төрөлхтний түүхэнд мандан бадарч байсан бусад эзэнт гүрнүүдийн гадаад бодлогоос эрс ялгарч байсныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм. Тухайн үед шашны хүчтэй нөлөөнд автсанаар хөгжлийн хувьд Дорноос хоцроод байсан Өрнөд төдийгүй Ойрхи Дорнод, Дундад Азийн лалын улс гүрнүүд, Азийн бусад улсууд үндсэндээ олон улсын эрх зүйт харилцаагүй байсан ба өөрийн эрх ашгийн үүднээс гадны элч төлөөлөгчдийг үл хүндэтгэдэг төдийгүй хэрцгийгээр хандан алах хүртэл хэвийн үзэгдэл болж, улс хоорондын харилцаанд "сул дорой нь бусдад идэгдэж, хүчтэй нь дотроосоо идэгдэнэ"

<sup>2</sup> Felipe Fernandez-Armesto., "Civilizations. Culture, Ambition, and the Transformation of Nature", NY.2001, pp.113-117

<sup>3</sup> А.Дж.Тойнби., "Постижение истории", М.2002., стр. 147-148



гэсэн хууль үйлчилж байсан цагт монголчууд анх түрүүнд гадны элч төлөөлөгчдийг хүндэтгэн харьцах, элчийг эс хүндэтгээнд “*pacta sunt servanda*” зарчмыг баримтлахыг олон улсын хэмжээнд хэвшүүлэх, улс хооронд элчин хүн чөлөөтэй айх аюулгүй зорчих эрх зүйн орчныг “гэрэгэ” бичгээр дамжуулан үүсгэх, техник дэвшлийн хөгжлийн байдлаас шалтгаалан харилцаа холбоо сул байсан нөхцөлд өртөө албыг үүсгэн богино хугацаанд хэрэгцээт мэдээллээр хангах олон улсын механизмыг үүсгэсэн зэргээр олон дэвшилтэт алхмуудыг хийсэн төдийгүй хамгийн гол нь Их Монгол улсын бүрэлдэхүүнд болон нөлөөнд байсан улсуудын хөгжлийн хол зөрүүтэй байдлыг багасгаж, тэднийг хөгжлийн хувьд ойртуулж чадсанд оршино.

Их Монгол улсын үеийн гадаад бодлого нь олон чиглэлтэй, идэвхтэй байсан бөгөөд “энхээр төвшитгөх” үзэл санаагаар илэрч байлаа. Их Монгол улсын гадаад бодлого дахь “монгол энх төрийн” үзэл санаа нь хүчний тэнцвэрийн зарчмыг сайтар ойлгож байсныг гэрчилдэг. Энэ утгаар бид олон улсын харилцааны онолын урсгалууд нь Европ төвтэй бөгөөд тухайлбал, улс төрийн реализмын сонгодог ухагдахуун болох хүчний тэнцвэрийн тухай ойлголтыг европчууд XIX зуунд үүсгэсэн гэдэг зарчмыг эргэж харах саналыг дэвшүүлж байна. Хүчний тэнцвэр нь олон улсын харилцааны бүс нутгийн эсвэл дэлхийн хэмжээнд үйлчилж байгаа системийн тогтвортой байдлыг хангахаар зохицуулагч их гүрнүүд хооронд үүссэн хүчний болон ашиг сонирхлын тэнцвэрт байдал гэж товчхоноор ойлгож болно. Үйлчилж буй системийн тогтвортой байдлыг хадгалахын тулд илүү хүчирхэгжсэн их гүрэн болон өрсөлдөгчийн эсрэг бусад их гүрнүүд улс төрийн болон цэрэг зэвсгийн хувьд хамтрах, эдийн засгийн болон улс төр, цэрэг дайны нэгдсэн бодлого явуулах зэргээр Европт олон улсын харилцаа хүчний тэнцвэрийн хуулиар хөгжиж төлөвшсөн нь үнэн боловч үүнээс хэдэн зууны өмнө, тухайлбал, XIII-XIV зуунд монголчууд нөлөө бүхий улс гүрнүүдтэй найрсаг харилцахыг эрхэмлэх, өрсөлдөгчийн эсрэг хамтран цэрэг-улс төрийн эвсэл байгуулах санал тавих зэргээр хүчний тэнцвэр үүсгэхийг чухалчилсан гадаад бодлого явуулж байсныг түүхийн олон эх сурвалжаар нотолж болно.

Эдгээр эх сурвалжууд дотроос дипломат харилцаа болон Их Монголын гадаад бодлогын түүх судлалд тэргүүлэх ач холбогдолтой нь Их Монгол улсын хувь улсуудын нэг болох Илхаадын улсын хаадуудаас Ромын Пап, Өрнөдийн хаадуудад илгээсэн олон тооны дипломат захидлууд мөн. Тухайлбал, бидний сонирхлыг ихэд татсаар ирсэн хоёр захидал бол 1289 онд Илхаан Аргунаас, 1305 онд Илхаан Өлзийтөөс Францын хаан



Филиппэд илгээсэн захидлууд юм. Дээрх захидлуудыг хэл шинжлэл, түүхийн талаас судалсан олон судалгаа, орчуулгууд байдаг. 1289 оны Аргун хааны захидлын гол утга нь Египетийн эсрэг Өрнөдтэй цэрэг-улс төрийн эвсэл байгуулж, улмаар хамтын хүчээр Сири, Палестинийг байлдан дагуулах асуудлаар хийсэн тов юм. Энэхүү захидлын үг хэллэгийг дундад үеийн монгол хэлнээс орчин цагийн монгол хэлэнд буулгасан А.Мостэрт, Ф.В.Кливз нарын орчуулгаас харахад Илхааны улс нь Өрнөдийн улсуудтай холбоотон болохыг эрмэлзэж хэд хэдэн удаа элч зарсны дунд Францтай зөвшилцөлд хүрч Египетийн мамлюкуудын эсрэг цэрэг-улс төрийн эвсэл байгуулахаар тогтсон бөгөөд зарим асуудлаар нарийвчилсан тодруулга хийсэн байдаг. Захидалд гарах олон үгс хийгээд утга нь тэр цагт монголчууд хүчний тэнцвэрийг сайтар ойлгож байсныг нотолж байдаг. Тухайлбал, захидал дахь "хамсах"<sup>4</sup> гэдэг нь холбоотон болж хамтран довтлох гэсэн утгыг тод илэрхийлж байх жишээтэй. Мөн "Тэд иргэнийг авбаас Иерусалимыг өгье"<sup>5</sup> гэсэн нь холбоотны хувьд Францын ашиг сонирхлыг сайтар ойлгож байсныг нотолдог. Аргун хааны Өрнөдийн улсуудад илгээж байсан захидлууд дотор\* загалмайтны шашинд хүндэтгэлтэй ханддаг тухай санаа тод байдаг нь Өрнөдийн улсуудын хүчийг зөв үнэлэн, олон улсын харилцааны нөхцөл байдлыг сайтар ойлгож, эзэнт гүрний хувьд Өрнөд Европыг байлдан дагуулах бус, харин холбоотон байхыг чухалчилж, тэнцвэрт олон улсын харилцааны тогтолцоо үүсгэхийг чармайж байсны илрэл гэж үзэж байна. Зөвхөн Аргун төдийгүй Их Монголын их хаадуудаас, тухайлбал, Гүюг хаанаас Ромын Папад, Мөнх хаанаас Францын хаан IX Людовикт, Ил хаан Абага, Газан, Өлзийт нараас Ромын Пап болон Өрнөдийн хэд хэдэн улсын хаадад удаа дараа элч зарж байсан, дипломат захидал илгээж байсан зэргээс харахад "монгол энх төрийн" үзэл санааны үндсэн зарчим нь олон улсын харилцаанд хүчний тэнцвэрт байдлыг үүсгэхээр илэрч байжээ гэж үзэхэд хүргэж байгаа юм. Францын хаан Филиппэд Илхаан Өлзийтээс илгээсэн захидал нь Аргун хааны захидлуудаас дутахгүй ач холбогдолтой.

Захидлын гол санаа нь Өлзийтөөс өмнө Илхааны улс, Францын хооронд тогтсон найрсаг харилцааг үргэлжлүүлэх, үүсээд байгаа хүчний тэнцвэрийг цаашид ч хадгалах эрмэлзлийг илэрхийлж байдаг. В.Котвич захидлын ач холбогдлыг өндөр үнэлсэн байдаг<sup>6</sup>

<sup>4</sup> А.Мостэрт, Ф.В.Кливз., "Илхаан Аргун, Өлзийт нараас 1289, 1305 онд Гоо Филиппт илгээсэн захидлууд", орч.Т.Төмөрхүлэг., УБ.1998, х.52

<sup>5</sup> А.Мостэрт., х.56

\* 1289 оны дээрх захидлаас гадна Аргун хаан Өрнөдийн улсуудад хандан 4 удаа дипломат захидал илгээсэн баримт байдаг.

<sup>6</sup> В.Котвич., "XIII зууны эхэн үед монголчууд дэлхий нийтийн энх тайвны санааг сэдэж үүсгэсэн болох нь", "Монгол судлал" 1972, 205-207-р тал



бөгөөд үнэхээр ч Илхаан Өлзийтийн захидалд олон улсын хэмжээнд дайнаас татгалзаж, энхийг эрхэмлэхийг уриалан дэвшүүлсэн санаа байдаг нь олон улсын харилцааны хүчний тэнцвэр бүхий тогтвортой системийг үүсгэхийг чухалчилж байсны нэг тод илрэл мөн. Уг захидалд гарах "хаан ширээ залрах үед нэгэнт тогтчихсон байсан журмыг өмнө засаглаж байсан сайчуудтай зөвшилцсөнийг хэрхэвч олтгойдуулахгүйгээр андгай мэт үзэн урьдаас бүр ч үлэмж найрамдаж элч нараа харилцан илгээхийг зорьж амуй"<sup>7</sup> гэснээс харахад Өрнөдийн улсуудтай цаашид ч найрсаг харилцаж, улмаар олон улсын харилцааны тэнцвэрт тогтолцоог төлөвшүүлж, энх тайван байдлыг тогтоохыг эрмэлзсэн санаа тод байна. "Эдүгээ бидэнтэй болон та нартай үл эвсэгчдийн эсрэг .... бүгдээрээ хамсарч тэмцэхийг Тэнгэр мэдтүгэй"<sup>8</sup> гэсэн төгсгөлийн үгэнд зөвхөн холбоотны харилцаагаа хадгалах сонирхлыг илэрхийлээд зогсохгүй үүсэн бий болсон олон улсын харилцааны дэг журмыг хадгалах зохицуулагч их гүрнүүд байх санал тод байгаа юм. Дээрх захидлаас харахад тухайн үед хэвшмэл байсан бусад хүчирхэг өрсөлдөгчдийг цэрэг дайны аргаар унагах замаар эзэнт гүрэн өөрийн үүсгэсэн системийг бусдад тулгахыг эрмэлзэж байдаг гэсэн зарчмыг үгүйсгэж болно. Монголчуудын хотол их улсыг байгуулах үзэл санаа нь дэлхийн талыг эзэлсэн байлдан дагуулал, эзэнт гүрнийг үүсгэсэн боловч энэ нь "энхээр тохинуулах" үзэл санаа байсан гэдгийг дээрх захидлууд давхар нотолж байдаг. "Монгол энх төрийн" үзэл санааны нэг тод илрэл нь олон шашинд адил тэгш хандаж байсан байдал юм. Зөвхөн Монголд төдийгүй нийт эзэнт гүрний газар нутаг дээр бүх шашныг адил хүндэтгэж үзнэ гэсэн хууль цааз үйлчилж байсан нь үүний нэг тод илрэл бөлгөө.<sup>9</sup> Мөн харийн газар нутгийг байлдан дагуулахдаа урьд сайн дураар бууж өгөх санал тавьдаг байсан нь энхээр тохинуулах үзэл санаа мөн.

Олон улсын харилцааны гол зүй тогтол болох хүчний тэнцвэрийн хуулийг сайтар ойлгож байсан монголчууд Египетийн эсрэг цэрэг-улс төрийн эвсэл байгуулах бодит хүчин төдийгүй Их Монголтой харилцах түвшний улсууд гэдэг утгаар Өрнөдийн улсуудтай харилцаж байсан. Хэрвээ хүчний тэнцвэрийг ойлгодоггүй байсан бол хүчээ тарамдаж дуустал аян дайн хийсээр төрөө тохинуулж чадахгүй байсан буй заа. Цаг үеийнхээ хамгийн хүчирхэг хэт их гүрэн гэдгээ мэдэрч байсан монголчууд арабууд шиг байлдан дагууллаар дамжуулан өөрийн шашныг бусдад хүчээр нялзаахыг оролдоогүй,

<sup>7</sup> А.Мостэрт, Ф.В.Клисс., "Илхаан Аргун, Өлзийт нараас 1289, 1305 онд Гоо Филиппт илгээсэн захидлууд", орч.Т.Төмөрхүлэг., УБ.1998, х.86

<sup>8</sup> А.Мостэрт., х.86-87

<sup>9</sup> С.Нарангэрэл. "Монголын эрх зүйн түүхэн тойм. Монголын эрх зүйн хөгжилт: он дараалал, үндсэн үе шат", Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал", УБ.2001, х.31



ромчууд шиг хүчээ тарамдаж дуустал байлдан дагуулал хийгээгүй, Өрнөд шиг соёл иргэншлийн үнэт зүйлсээ бусдад түгээж, хүчээр "шинэчлээгүй". Монголчууд өөрийн эзэнт гүрний хэмжээнд соёл иргэншлүүд өөр хоорондоо харилцан хүндэтгэлтэй зэрэгцэн орших эрх зүйт төрийн бодлогыг амжилттай цогцлоож чадсан бөлгөө.

Эзэнт гүрэн хүчирхэгжихийн хэрээр өрсөлдөгчөө унагах, байлдан дагуулахыг эрмэлзэж байдаг зүй тогтол зонхилж байсан нөхцөлд монголчууд эсрэгээр хүчний тэнцвэрт байдал үүсгэн, энхээр зэрэгцэн орших санал тавьж байсан хийгээд "монгол энх төрийн" үзэл санаагаар илэрч байсан Их Монгол улсын гадаад бодлого идэвхтэй бөгөөд дэвшилтэт байсан нь сонирхолтой төдийгүй цаашид судлууртай сэдэв мөн.

**Ашигласан материал:**

1. Ж.Баясах. "Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг", УБ.2005
2. Ж.Бор. "Монгол хийгээд Евразийн дипломат шастир. II боть", УБ.2004
3. Ч.Жүгдэр. "Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг" УБ.1990
4. Д.Майдар. "Чингис хаан ба Монголын их гүрэн", УБ.1990
5. "Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэлийн асуудал" эрхэлсэн Ж.Болдбаатар., УБ.2001
6. "Монголын эзэнт гүрний гадаад харилцаа", хянан найруулсан Н.Ишжамц, УБ.1995
7. А.Мостэрт, Ф.В.Кливе "Илхаан Аргун, Өлзийт нараас 1289, 1305 онд Гоо Филиппт илгээсэн захидлууд", орч.Т.Төмөрхүлэг, УБ.1998
8. Ж.Ж.Саундерс. "Монголын байлдан дагуулал", орч.Ж.Гэндэндарам., УБ.,1992
9. Орос хэлээр
10. К.С.Гаджиев. "Геополитика", М.1997
11. А.Дж.Тойнби. "Постижение истории", М.2002
12. А.Дж.Тойнби. "Цивилизация перед судом истории", М.2003
13. П.А.Цыганков. "Теория международных отношений", М.2005
14. 1.Felipe Fernandez-Armesto. "Civilizations. Culture, Ambition, and the Transformation of Nature. NY., 2001
15. 2.Samuel P.Huntington.The Clash of Civilizations and the Remarking of World Order, NY.,1996